



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 0/45

Улаанбаатар хот

Төрийн үйлчилгээний албан тушаалын  
цалинг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоол, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоол, “Журамд өөрчлөлт оруулах тухай” 491 дүгээр тогтоол, Газрын дүрмийн 7.1.1, 7.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээнд өөрчлөлт орсонтой холбогдуулан батлагдсан цалингийн санд багтаан, газрын төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг нэмэгдүүлсэн өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

2.Шинэчлэгдсэн цалингийн хэмжээг Хүний нөөцийн болон Цалингийн нэгдсэн системд бүртгэж оруулан Төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдад 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг агентлаг хариуцсан Ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ

d:\hotiin\_standard\2023\_a\_tushaal\_blank.docx

1150500209